



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хотонт сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2025/12-НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Архангай аймаг 2024 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: <a href="mailto:Baigalmaat@audit.gov.mn">Baigalmaat@audit.gov.mn</a> Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: <a href="mailto:Nerguibaatard@audit.gov.mn">Nerguibaatard@audit.gov.mn</a> Аудитор В.Цогжаргал Цахим хаяг: <a href="mailto:Tsojargalb@audit.gov.mn">Tsojargalb@audit.gov.mn</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	2
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
<b>3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	8
<b>3.1 Албан шаардлага</b> .....	8
<b>4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	9
ХХС-д 70,935.2 мянган төгрөгийн чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна. ....	9
4 нэр төрлийн орлого 38,793.2 мянган төгрөгөөр тасарсан байна.....	9
ТТЗ-ийн дотоод хяналт хангалтгүй байна. ....	9
<b>5.НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ</b> .....	10

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.03.25 № 167  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХОТОНТ СУМЫН ЗАСАГ  
ДАРГА П.БАТЖАРГАЛ ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Хотонт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

#### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Сумын 2024 оны төсвийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 371,910.4 мянган төгрөгөөр давж биелсэн хэдий ч 4 нэр төрлийн орлогыг төлөвлөснөөс 38,793.2 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн.
2. Хоршоо хөгжүүлэх сангийн 25 зээлдэгчтэй холбоотой 70,935.2 мянган төгрөгийн чанаргүй хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй;

Дээрх зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээр санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.10, 37 дугаар зүйлийн 37.1, 37.1.1, 37.1.5, 41 дүгээр зүйлийн 41.2.1, ХХААХҮС-ын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.4.11, 10 дугаар зүйлийн 10.1, 11 зүйлийн 11.3, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3 дугаар зүйлийн 3.9.7 дахь

заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Аудитын гол асуудал**

Тайлант онд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэл засаглалын удирдлага, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, соёл урлаг, ерөнхий боловсрол, эрүүл мэндийн бодлого удирдлага, сургуулийн өмнөх боловсрол гэсэн 8 хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд зориулан 2,460,961.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 2,166,325.0 мянган төгрөгийг зарцуулж, төлөвлөснөөс 294,636.3 мянган төгрөг зарцуулагдаагүй байна. Үүнээс 236,806.8 мянган төгрөг ОНХС, ХХС-ийн зарцуулагдаагүй үлдэгдэл бол 57,829.5 мянган төгрөг нь төсөвт байгууллагуудын ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн төсвийн үлдэгдэл байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Сумын засаг дарга нь 2024 онд аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран 15 үндсэн зорилтын хүрээнд 105 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 74.4 хувьтай үнэлсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	662,375.4	743,703.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	251,949.7	379,110.1
33	АВЛАГА	362,946.4	288,157.7
35	БАРАА МАТЕРИАЛ	47,479.4	56,595.3
36	НӨӨЦИЙН БАРАА	0.0	19,840.0
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	2,392,234.8	2,582,007.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,392,234.8	2,582,007.9
39200	Биет хөрөнгө	2,352,224.8	2,541,997.9
39300	Биет бус хөрөнгө	40,010.0	40,010.0
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	3,054,610.2	3,325,711.1
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	2,340.0	0.0
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	2,340.0	0.0
41300	Өглөг	2,340.0	0.0
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	3,052,270.2	3,325,711.1
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,052,270.2	3,325,711.1
51100	Засгийн газрын оруулсан капитал	545,657.5	545,657.5
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,633,280.2	1,906,721.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	873,332.5	873,332.5
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	3,054,610.2	3,325,711.1

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	2,738,920.2	2,242,478.1
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	562,837.7	959,718.5
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	336,591.8	695,336.8
<b>1100</b>	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	336,542.2	695,218.0
<b>1102</b>	<b>Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч</b>	49.5	118.8
<b>113</b>	<b>Хөрөнгийн албан татвар</b>	106,110.6	193,836.6
<b>118</b>	<b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>	120,135.4	70,545.1
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	416,702.3	359,237.2
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	416,702.3	359,237.2
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	1,759,380.2	923,522.4
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	2,132,510.5	1,507,190.1
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,132,510.5	1,487,190.1
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,083,830.5	1,416,978.1
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	479,061.2	745,338.6
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	59,765.0	92,276.3
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	24,693.6	206,052.9
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	68,165.6	92,007.8
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,815.3	33,446.1
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,766.0	5,703.6
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	194,172.8	45,335.9
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	245,391.0	196,816.7

Архангай аймгийн Хотонт сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,048,680.0	70,212.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	20,000.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	606,409.7	735,288.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	313,285.0	418,639.9
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	293,124.7	316,648.1

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,460,778.5	2,037,006.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	562,837.7	959,718.5
110	Орлогын албан татвар	336,591.8	695,336.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	336,542.2	695,218.0
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	49.5	118.8
113	Хөрөнгийн албан татвар	106,110.6	193,836.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	120,135.4	70,545.1
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	15,204.6	10,819.5
1181	Газрын төлбөр	45,352.6	36,855.1
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	59,578.3	22,870.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	136,220.6	153,765.7
120	Нийтлэг татварын бус орлого	136,220.6	153,765.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,761,720.2	923,522.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,936,990.2	1,354,006.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,936,990.2	1,354,006.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	886,710.3	1,281,764.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	477,870.2	741,194.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,635.0	92,276.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,693.6	206,052.9
2104	Хангамж, бараа материалын зардал	51,973.0	50,519.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,800.0	27,876.1
2107	Томилолт, зочны зардал	4,766.0	5,703.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	196,097.2	60,360.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,875.4	97,780.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,050,280.0	72,242.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	523,788.2	683,000.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	318,286.8	485,839.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	318,286.8	485,839.9
2200	Дотоод эх үүсвэрээр	318,286.8	485,839.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-318,286.8	-485,839.9
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-75,000.0	-70,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	75,000.0	70,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	130,501.4	127,160.4

Архангай аймгийн Хотонт сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	121,448.3	251,949.7
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	251,949.7	379,110.1

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,759,265.5	2,759,265.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-120.0	-120.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,759,145.5	2,759,145.5
9	Тайлант үеийн үр дүн	293,124.7	293,124.7
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,052,270.2	3,052,270.2
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,052,270.2	3,052,270.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-43,207.2	-43,207.2
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,009,063.0	3,009,063.0
19	Тайлант үеийн үр дүн	316,648.1	316,648.1
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,325,711.1	3,325,711.1

#### 2.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,166,242.70	1,886,146.42	280,096.28	87.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,374,116.20	1,335,006.51	39,109.69	97.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,301,864.20	1,262,764.51	39,099.69	97.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	761,504.00	741,194.45	20,309.55	97.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,788.00	92,276.34	2,511.66	97.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	218,786.00	206,052.93	12,733.07	94.2
2104	Хангамж, бараа материалын зардал	50,823.20	50,519.46	303.74	99.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,696.10	31,076.10	2,620.00	92.2
2107	Томилолт, зочны зардал	5,800.00	5,703.60	96.40	98.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,151.40	40,661.12	490.28	98.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	95,315.50	95,280.50	35.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,252.00	72,242.00	10.00	100.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	15,750.00	15,750.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,502.00	56,492.00	10.00	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	549,366.50	481,139.91	68,226.59	87.6

Архангай аймгийн Хотонт сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>242,760.00</b>	<b>70,000.00</b>	<b>172,760.00</b>	<b>28.8</b>
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,166,242.70</b>	<b>1,949,408.61</b>	<b>216,834.09</b>	<b>90.0</b>
32	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,517,372.50</b>	<b>1,821,422.65</b>	<b>(304,050.15)</b>	<b>120.0</b>
320001	Орон нутгийн төсвөөс	1,301,088.10	1,605,138.25	(304,050.15)	123.4
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	216,284.40	216,284.40	-	100.0
35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>648,870.20</b>	<b>127,985.95</b>	<b>520,884.25</b>	<b>19.7</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	257,750.00	127,985.95	129,764.05	49.7
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	391,120.20	-	391,120.20	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	100,911.60	(100,911.60)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	164,173.79	(164,173.79)	
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>58.00</b>	<b>58.00</b>	<b>0.0</b>	
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>2.00</b>	<b>2.00</b>	<b>0.0</b>	
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>28.00</b>	<b>28.00</b>	<b>0.0</b>	
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>28.00</b>	<b>28.00</b>	<b>0.0</b>	

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>23,699,825.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>23,699,825.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>23,699,825.00</b>
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,699,825.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,000,000.00
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>23,699,825.00</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,699,825.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар хоршоо хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланд 43,207.2 мянган төгрөгийн залруулга хийлээ.

Хотонт сумын Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/10 дугаар “Хоршоо хөгжүүлэх сангийн зээлдэгчийн алдааг залруулах ажлыг хэсгийг томилох тухай” захирамжаар хоршоо хөгжүүлэх сангийн санхүүгийн тайлан болон программын бүртгэлийн зөрүүг арилгах ажлын хэсгийг байгуулж ажиллуулсан байна.

Ажлын хэсгийн шийдвэрийг үндэслэн сумын засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн “Хоршоо хөгжүүлэх сан, санхүүгийн программд шивэгдсэн алдааг залруулах тухай” А/15 дугаар захирамжаар 42 зээлдэгчийн зээлийн үлдэгдлийг зөврүүлэн нийт 43,207.2 мянган төгрөгөөр санхүүгийн тайлан дахь авлагын эхний үлдэгдлийг багасган, өмнөх үеийн үр дүнг бууруулах залруулга хийлээ.

Аудитаар залруулагдаагүй нийт 109,728.4 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч зөрчлийг арилгуулах 3 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 3 зөрчилтэй асуудлын материаллаг мөнгөн дүн 109,728.4 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 15,163.7 мянган төгрөгөөс их, сумын засаг даргын санхүүгийн алба, төрийн сангаас өдөр тутам төсвийн гүйлгээнд тавих хяналтгүйгээс орон нутгийн удирдлагын байгууллагуудын тайланд 35,804.6 мянган төгрөгийн материаллаг зөрчил илэрч хязгаарлалттай дүгнэлт авсан байх тул Хотонт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “**Хязгаарлалттай**” дүгнэлт өглөө.

#### 3.1 Албан шаардлага

3.1.1 Сумын төсвийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлээр 4 нэр төрлийн орлого 38,793.2 мянган төгрөгөөр тасарч, орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Сумын орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллах, орлогыг сар улирлын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

3.1.2. Хоршоо хөгжүүлэх санд 25 зээлдэгчтэй холбоотой 70,935.2 мянган төгрөгийн чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, 10 дугаар зүйлийн 10.1-т “Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина”, 11 зүйлийн 11.3-т “Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг таслан зогсоож, хоршоо хөгжүүлэх сангийн чанаргүй зээлийн авлагыг барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.1.3. Тайлант онд сумын засаг даргын санхүүгийн алба, төрийн сангаас өдөр тутам төсвийн гүйлгээнд тавих хяналтгүйгээс орон нутгийн удирдлагын байгууллагуудын тайланд 35,804.6 мянган төгрөгийн материаллаг зөрчил илэрч хязгаарлалттай дүгнэлт авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.10-т “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 37 дугаар зүйлийн 37.1-т “Төрийн сан дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 37.1.1-т “Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих”, 37.1.5-д “Төсвийн гүйлгээг цахим системээр хэрэгжүүлж хяналт тавих, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.9.7-д “Энэ журмын 3.9.3.3-т заасан дотоод хяналтыг бүх шатны төрийн сан үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг таслан зогсоож, сумын Засаг даргын дотоод хяналт, төсвийн байгууллагуудын гүйлгээнд сумын санхүүгийн алба, төрийн сангаас тавих өдөр тутмын хяналтын үр дүнг сайжруулах арга хэмжээг авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мян.төг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Төлбөрийн акт		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ХХС-д 70,935.2 мянган төгрөгийн чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна.	1	70,935.2			1	70,935.2
4 нэр төрлийн орлого 38,793.2 мянган төгрөгөөр тасарсан байна.	1	38,793.2			1	38,793.2
ТТЗ-ийн дотоод хяналт хангалтгүй байна.	1	0.0			1	0.0
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>109,728.4</b>			<b>3</b>	<b>109,728.4</b>

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мян.төг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс	
			Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил				
Тайлант хугацаанд шилэн дансанд 12 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.	1	0	1	0
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>

## 5.НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

/мян.төг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс:			
			Төлбөрийн акт		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг даргын тамгын газар	6	21,804.6	1	3,570.4	5	18,234.2
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	2	14,000.0			2	14,000.0
Хоршоо хөгжүүлэх сан	1	70,935.2			1	70,935.2
Орон нутгийн хөгжлийн сан	4	20,000.0			4	20,000.0
Төсвийн төвлөрүүлэн захирагч	2	38,793.2			2	38,793.2
<b>Дүн</b>	<b>15</b>	<b>165,533.0</b>	<b>1</b>	<b>3,570.4</b>	<b>14</b>	<b>169,103.4</b>